



Protecting the rights of migrant women and victims of human trafficking in Mongolia

Өнөөдөр, 7-р сарын 30 хүний наймааны эсрэг дэлхийн өдөр болохыг Монгол дахь ОУШХБ-аас онцлон мэдээлж байна .

Монгол дахь хүн худалдаалах гэмт хэргийн тархалт ноцтой нөхцөлд байгаа бөгөөд ялангуяа залуу эмэгтэйчүүд болон охидыг ашиг олох зорилгоор бэлгийн мөлжлөгт ашиглаж байна. 2007 оноос хойш, ОУШХБ хүний наймааны хохирогчдод шууд туслалцаа үзүүлэх, эргэн нийгэмшихэд нь дэмжлэг болох, түүнчлэн засгийн газар болоод хүний наймаатай тэмцдэг бусад байгууллагуудыг дэмжих тал дээр орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилласаар ирлээ.

Энэ оны нэгдүгээр сард, Монгол дахь ОУШХБ хүний наймааны хохирогчийг болон шилжин суурьшигчийг эрсдлээс хамгаалах зорилгоор 2 жилийн хугацаатай төсөл эхлүүлсэн. Энэ төслийг Европын холбооны ардчилал, хүний эрхийг дэмжих байгууллагатай хамтран санхүүжүүлж байна. Монголын талаас Гадаад хэргийн яам, Хууль зүйн яам, Монголын хүний эрхийн үндэсний комисс болон уул уурхайн компаниудтай хамтран ажилладаг.

“Энэхүү төсөл нь Өмнөговь, Дорноговь аймагт буюу Монгол дахь уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй бүс нутагт хэрэгжинэ. Монголын өмнө зүгийн нутаг дахь уул уурхайн салбарын хөгжил нь уул уурхайн бүс нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлж байна. Энэхүү эмх замбараа муутай шилжилт хөдөлгөөн нь зарим эрсдэл, тухайлбал хил дамнасан хүний наймааны эрсдлийг нилээдгүй нэмэгдүүлээд байгаа юм. Иймд мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэх, удирдлага, зохицуулалтаа сайжруулах, шилжин суурьшсан эмэгтэйчүүдийн эрсдлийг бууруулах, хүний наймааны хохирогчдод шууд туслалцаа үзүүлэх зэрэгт анхаарах нэн шаардлагатай байна.” хэмээн ОУШХБ-ын салбарын захирал ноён Пар Лилжерт онцлон тэмдэглэсэн.

Төслийн үйл ажиллагаанаас дурьдвал, өнгөрсөн 4-р сард хохирогчийг хамгаалах, үйлчлүүлэгчийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлэх, хүний наймаанаас урьдчилан сэргийлэх цуврал сургалтыг ОУШХБ-аас зохион явуулж, орон нутгийн иргэний нийгмийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн нийгмийн ажилтнууд болон орон нутгийн ИХШХБ, цагдаа, захиргааны 100 гаруй ажилтанг хамруулсан. Дурьдсан сургалт, семинарууд Дорноговь, Өмнөговь аймгийн өмнөд сумд болон нийслэл Улаанбаатар хотод явагдсан.

Төслөөр хүний наймааны хохирогчийг эргэн нийгэмшихэд нь туслах, эмзэг бүлгийн шилжин суурьшигчид, нүүрсний тэрэгний жолооч нар, сургуулийн сурагчдад зориулсан мэдлэг мэдээлэл нэмэгдүүлэх аян өрнүүлэх, уурхай даган шилжин суурьшсан эмэгтэйчүүдэд амьжиргаагаа дээшлүүлэхэд нь зориулсан сургалт явуулах, орлого олоход нь тус болох гарааны мөнгөн тусламж үзүүлэх, шилжин суурьшигчдын мэдээллийн төв байгуулах зэрэг ажил хийгдэнэ.



Protecting the rights of vulnerable migrants and victims of human trafficking in
Mongolia

Төслийг хэрэгжүүлэхэд Хүйсийн тэгж эрхийн төв (ХТЭТ) болон ЭКПАТ Монгол сүлжээтэй хамтран ажиллаж байгаа юм. Дэлгэрэнгүй мэдээллийг төслийн материалаас үзнэ үү www.iom.int/countries/mongolia

Мэдээлэл авахыг хүсвэл доорх хаягаар холбоо барина уу:

Рэнцэндоржийн Оюунбилэг (ОУШХБ Монгол)

И-мэйл хаяг: orentsendorj@iom.int Утас: +976 70143100